

23



2014 оны 06 сарын 22-ны өдөр

## Эрсдлийн сангийн дотоод журам

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмаар "БидиСЕК" ХК-ийн эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтний буруутай үйл ажиллагаанаас харилцагчид учруулсан хохирлыг барагдуулах зорилгоор эрсдлийн санг бүрдүүлэх, түүний хөрөнгийг хадгалах, ашиглах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Харилцагч гэдэгт ҮЦК-тай байгуулсан үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээний гэрээний хүрээнд үйлчлүүлж буй хувь хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

### Хоёр. Эрсдлийн сан байгуулах

2.1 Компани нь үйл ажиллагааны эрсдлээс өөрийн харилцагч, хөрөнгө оруулагчдад учирч болзошгүй эрсдлээс хамгаалах зорилгоор эрсдлийн санг байгуулна.

2.2 Эрсдлийн санг Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам"-д заасны дагуу компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 3-аас доошгүй хувьтай тэнцэх хөрөнгөөр байгуулж ажиллана.

2.3 Эрсдлийн сангийн мөнгөн хөрөнгийг арилжааны банкинд байгууллагын үйл ажиллагааны мөнгөн хөрөнгөөс тусад нь данс нээж тогтмол байршуулна.

2.4 Компанийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон ашиг, хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр эрсдлийн сангийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх бөгөөд түүнийг нэмэгдүүлэх эх үүсвэрийн тооцоолол, үндэслэлийг гүйцэтгэх захирлын өргөн мэлүүлснээр компанийн Төлөөлөн удирдах зөвлөл баталгаажуулна.

### Гурав. Эрсдлийн санг зарцуулах, нөхөн дүүргэх

3.1 Компани, түүний ажилтан, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас харилцагчид хохирол учруулсан нь баримтаар нотлогдвол дотоод хяналтын ажилтан гүйцэтгэх удирдлагад танилцуулж хохирлыг сангаас барагдуулна.

28

### Зургаа. Бусад

- 6.1 Компанийн гүйцэтгэх захирал гарын үсэг зурж, компанийн тэмдэг дарсан өдрөөс эхлэн журам хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 6.2 Энэхүү журамд Гүйцэтгэх захирлын тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 6.3 Эрсдлийн сангийн зарцуулалтын тайланг нягтлан бодогч улирал бүр Гүйцэтгэх захиралд гаргаж өгнө.
- 6.4 Эрсдлийн сангийн энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

3.2 Компани нь үйл ажиллагааны эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийг тараан байршуулах зорилгоор харилцагчтай шууд харилцдаг мэргэжилтэнг мэргэжлийн хариуцлагын даатгалд хамруулна.

3.3 Компани эрсдлийн сангаас зарцуулсан хөрөнгийг холбогдох буруутай этгээд, албан тушаалтнаар төлүүлэх замаар санг нөхөн дүүргэж болно. Нөхөн дүүргэх хугацаа ажлын тав хоног байна.

3.4 Эрсдлийн санг зарцуулах шийдвэрийг Гүйцэтгэх захирал гаргаж, зарцуулалтад нягтлан бодогч, компанийн дотоод хяналтын ажилтан байнгын хяналт тавьж ажиллана.

3.5 Журмын 3.1-д заасан арга хэмжээ, Хорооны улсын байцаагчийн албан шаардлагаар харилцагчид учирсан хохирлыг компани өөр бусад хөрөнгөөр барагдуулж болох ба эрсдлийн сангаас хохирлыг барагдуулсан тохиолдолд ажлын 5 хоногийн дотор тогтоосон хэмжээнд нөхөн дүүргэнэ.

3.6 Эрсдлийн санг харилцагчийн гомдлыг барагдуулахаас өөр зорилгоор зарцуулахыг хориглоно.

#### **Дөрөв. Дотоод хяналтын ажилтны эрх, үүрэг**

4.1 Хяналтын ажилтан нь харилцагчаас ирүүлсэн гомдлыг шалган холбогдох дүгнэлтийг гаргана.

4.2 Компани, түүний ажилтан албан тушаалтан харилцагчид хохирол учруулсан нь баримтаар нотлогдвол хяналтын ажилтан нь Гүйцэтгэх захиралд тайлагнаж хохирол барагдуулах арга хэмжээг шуурхай авна.

4.3 Хяналтын ажилтан нь хохирлын шалтгаан холбогдох этгээдийг тодруулж, буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх арга хэмжээг зохион байгуулж, хийсэн ажлын тайланг Гүйцэтгэх захиралд танилцуулна.

4.4 Эрсдлийн сангийн үлдэгдлийн мэдээллийг Хорооны журмын дагуу улирал тутам хороонд хүргүүлэх үүргийг дотоод хяналтын ажилтан хариуцан ажиллана.

4.5 Хяналтын ажилтан нь компанийн үр ашигтай хяналтын тогтолцоог бүрдүүлэх, эрсдлийн бодлогын хэрэгжилт, явцад хяналт тавьж үнэлгээ дүгнэлт өгч, урьдчилан сэргийлэх арга аргачлалыг боловсруулж Гүйцэтгэх захиралд сар тутам, Санхүүгийн Зохицуулах Хороонд жил тутам хүргүүлнэ.

#### **Тав. Эрсдлийн сангийн бүртгэл хөтлөлт**

5.1 Эрсдлээс хамгаалах сангийн хөрөнгийг Хорооны НББ-ийн үлгэрчилсэн зааврын дагуу балансын активийн эргэлтийн хөрөнгө хэсэгт бүртгэнэ.

5.2 Эрсдлийн сангийн зарцуулалт нь компанийн зардал болно.

5.3 Эрсдлийн сан, түүний зарцуулалт нь компанийн санхүүгийн тайланд тусч байна.

5.4 Компанийн дотоод хяналтын ажилтан нь эрсдлийн сангийн хөрөнгийн бүртгэл хөтлөлтөд тогтмол хяналт тавина.